

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨРИЙН БОЛОН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН
АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, “ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН
БАТАЛГАА ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭПЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2024 оны 01 дугээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
 хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 01 дугээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдуулсан Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 01 дугээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нийслэлийн үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргах эрх зүйн орчныг бий болгох, Засгийн газраас зөвшөөрсөн тодорхой төсөл, арга хэмжээ, ёмне гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор гадаадын зах зээлд үнэт цаас гаргах, хөгжлийн болон томоохон төслийд санхүүжүүлэх боловсруулжийг бурддүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон холбогдох хуулийн төслийг боловсруулсан байна.

Мөн нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууринтуяа тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийтэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууринтуяа төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар гаргах нийслэлийн гадаад үнэт цааст зориулан 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаа гаргах нь зүйтэй гэж үзэж “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нийслэл хотын түгжрэл, агаар орчны бохирдлыг бууруулах, авто замын нэвтрэх чадварыг дээшгүүлэх чиглэлээр инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн төсөл, техник эдийн засгийн үндэслэл байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Өрийн удирдлагын тухай хуулийн өөрчлөлтийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, санхүүжилтийн арга замын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тотохсүрэн өргөн мэдуулсан хууль, тогтоолын төсөл нь Төсвийн тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуулийн шаардлагуудыг хангаж байгаа эсэх,

Засгийн газрын өрийн баталгаа гаргахад шаардах хуулийн тусгай шаардлагын нэг болох төсөл арга хэмжээний зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн эсэх, төсвийн хуульд заасан Засгийн газрын баталгааны дээд хязгаарт багтаж байгаа эсэх, төсөл арга хэмжээний төсвийн нарийвчилсан зардлын талаар асуулт асуулж хариулт авсан болно.

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, "Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэпцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, "Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэпцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.



ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ТОГТОХСҮРЭН